



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/35

Дэлгэрмөрөн

Төрийн болон орон нутгийн өмчийн
эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4, 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын 2022 оны А/247 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг тушаалаар байгуулж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт

2.Улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөөг батлуулж, мөрдөн ажиллах, тайлан, мэдээг нэгтгэж холбогдох шатны байгууллагад хүргэж ажиллахыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА  С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201069